

Монголын ОУИТБС-ын зургаадугаар тайлан буюу 2011 оны нэгтгэл тайлан

Олборлох үйлдвэрлэл Монгол Улсын эдийн засаг нийгмийн томоохон салбар болсныг гэрчлэх олон баримтын нэг нь манай улс 2011 онд алт 3 тонн, зэсийн баяжмал 573 мянган тонн, нүүрс 21 сая тонн, төмрийн хүдэр 5,7 сая тонн, газрын тос 2,5 сая баррелийг экспортод гаргажээ. Зөвхөн Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр дангаараа 2010 оны байдлаар ДНБ-ийн 12 хувийг үйлдвэрлэжээ. Тиймээс олборлох үйлдвэрлэлийг ил тод болгох нь чухал шаардлагын нэг болж байна.

Ил тод байдлын нэг чухал хэрэгсэл бол төлбөр, орлогын ил тод байдал бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нэг арга хэмжээ нь жил бүрийн нэгтгэл тайлан юм. Манай улс тайлангаа 2007 оноос эхлэн гаргаж, хэвлэн нийтэлж хэвшил болж одоо зургаадахь жилийнхээ тайланг гаргаад байна.

Британ улсын “Харт Нойрс” Лтд ба Монгол улсын “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн консерциум нь Монголын ОУИТБС-ын 6 дугаар тайлан буюу 2011 оны Нэгтгэл тайланг 2012 оны 8 дугаар сард эхлэж 11 дүгээр сард дуусгаад байна.

Энэхүү тайлан нь олборлох үйлдвэрлэлийн тэргүүлэгч 200 компаниас 2011 оны санхүүгийн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, талбөр, хураамж, ногдол ашиг болон төрийн санд төвлөрүүлсэн урьдчилгаа төлбөр, торгууль мөн төрийн байгууллагуудад олгосон хандив дэмжлэг гээд нийт 2,1 их наяд төгрөгийн орлогыг хүлээн авсан төр, засгийн бараг бүх шатны байгууллагуудтай нь тооцоо нийлж, нэгтгэсэн томоохон ажил хийгдсэн байна.

Эдгээр 200 компаниудаас 2011 онд хамгийн их орлого төвлөрүүлсэн компани нь уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр бөгөөд тэрээр 546 тэрбум төгрөг, удаад нь Оюу толгой 406,5 тэрбум, Тавантолгой 168,9 тэрбум, МАК 149 тэрбум, Энержи ресурс 83 тэрбум, Саусгоби сэндс 66 тэрбум, Петрочайна Дачин Тамсаг 56 тэрбум, Болд төмөр Ерөө гол 40 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

Эхний нэгтгэлээр Засгийн газрын талаас 1,8 их наяд төгрөгийн орлого, компаниудын талаас 1,3 их наяд төгрөгийн төлбөрийн санхүүгийн урсгал дүгнэгдэж, зөрүү 477 тэрбум төгрөг гарчээ. Хамрагдаагүй зөрүүтэй төлбөр, орлогод тайлан гаргаагүй 58 компанийн 433 тэрбум төгрөгийн төлбөр, Засгийн газрын зүгээс Оюу толгой компаниас хүлээн авсан 125 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн орлого ихэнхийг эзэлж байжээ.

Санхүүгийн эцсийн тохируулгын дүнд нийтдээ 2,1 их наяд төгрөгийн төлбөр орлого нэгтгэгдсэнээс 2 их наяд нь улсын төсөвт ноогдож, түүний 1,3 их наяд нь татвар, хураамж, 539 тэрбум нь Засгийн газрын бусад орлого, 65 тэрбум нь нийгэм эрүүл мэндийн даатгалын шимтгэл, 45 тэрбум нь төрийн өмчийн ногдол ашиг, 36 тэрбум нь төлбөр, 33 тэрбум нь хураамж үйлчилгээний хөлс байсан бол торгуулийн хэмжээ 2 гаруй тэрбум төгрөг байжээ.

Түүнчлэн орон нутгийн төсөвт нийт 66 тэрбум төгрөгийн төлбөр орлогыг нэгтгэсний 34 тэрбум нь орон нутгийн өмчийн ноогдол ашиг, 26 тэрбум нь төлбөр, 4,8 тэрбум нь татвар, 447 сая төгрөг нь хураамж үйлчилгээний хөлс, харин 175 сая төгрөг нь торгууль байжээ.

Мөн төрийн байгууллагад өгсөн хандив дэмжлэгийн дүн 26 тэрбум төгрөг болж нэгтгэгдсэн бол байгаль хамгаалах зардлын урьдчилгаа 1,2 тэрбум байсныг нотолжээ.

Шийдэгдээгүй эцсийн зөрүү нь нийгэм эрүүл мэндийн даатгалын шимтгэл дээр 169 сая, хандив дэмжлэг дээр 137 сая, төлбөр дээр 124 сая, орон нутгийн төлбөр дээр 46 сая, татвар хураамж дээр 44 сая төгрөг буюу нийт 622 сая төгрөгийн зөрүү байна гэж үзжээ. Үүнээс 273 сая нь компаниудтай, 348 сая нь Засгийн газрын байгууллагуудтай холбоотой байна гэжээ.

Энэ тайлангаар нотлогдсон хандив, дэмжлэг хүлээн авсан байдлыг үзүүлэхэд төрийн захиргааны төв болон харьяа байгууллагууд 14,8 тэрбум, орон нутгийн байгууллагууд, тухайлбал Архангай 50 сая, Баян-Өлгий 8,2 сая, Баянхонгор 419 сая, Булган 492 сая, Говь-Алтай 161 сая, Дархан-Уул 36,6 сая, Дорноговь 1,2 тэрбум, Дорнод 479 сая, Дундговь 108 сая, Завхан 3 сая, Орхон 33,2 сая, Өвөрхангай 172 сая, Өмнөговь 4,5 тэрбум, Сүхбаатар 627 сая, Сэлэнгэ 2,4 тэрбум, Төв 567 сая, Увс 101 сая Ховд 282 сая, Хөвсгөл 108 сая, Хэнтий 128 сая төгрөгийн хандив дэмжлэг хүлээн авсан байна.

Тайлангийн хүрээнд хандив тусламжийг бүртгэх, тайлагнах тухай Сангийн сайдын 2010 оны 45 тоот тушаалын биелэлтэд судалгаа хийхэд төр засгийн ихэнх байгууллагууд болон аймаг орон нутгийн удирдлагууд мөрдөж ажиллаагүй байна.

Мөн энэ тайланд нэгтгэгдсэн хандив дэмжлэгийн 46 хувийг Оюу толгой, 15 хувийг Бороо гоулд, 6,5 хувийг Энержи ресурс, 5,1 хувийг МАК, 4,7 хувийг Болд төмөр Ерөө гол олгосон бол Эрдэнэт үйлдвэр 2,4 хувийг нь гаргажээ.

Нэгтгэлд нийтдээ 31 яам агентлаг, 33 төсвийн байгууллага, 21 аймаг, 198 сум, 8 дүүрэг их бага хэмжээгээр оролцоноос, оролцооны үнэлгээгээр Засгийн газрын 2, орон нутгийн 8 байгууллага, 28 компани хангалтгүй гэсэн дүн авчээ.

Хангалтгүй гэсэн үнэлгээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Сэлэнгэ, Увс, Ховд, Дундговь, Өмнөговь аймгууд, харин компаниудаас Алтан Дорнод, Бату Майнинг, Гацуурт, ГБНБ, ЗөЮүЭ, Их Хан уул, Тавантолгой ХК, Ханшижир, Биг Могол Коул энд Энержи, Болд төмөр Ерөө гол, Брод, Буман- Олз, Бумбат, Геомин, Гүнбилэг трейд, Гүнбилэг гоулд, Дэлгэр- Орчлон, Жинхуа-Орд, Монгол алтай ресорсиз, Монгол метал майнинг, Олон овоот гоулд, СиӨүЭйЭл, СиСиЭм, Хотгор шанага, Хүдэн, ЭмАрСиЭмЖиЭл, Эрдэнэ жас, Эрдэнэс тавантолгой тус тус авчээ.

Нэгтгэлийн үеэр компаниудын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын мөрдөлт ямар байгаад судалгаа хийсэн.

Судалгаанд нэгтгэлд орсон 200 компанийн 176 нь оролцож, 24 нь огт хариулаагүй байна. Судалгаанаас харахад ойролцоогоор 54 хувь нь тухайн стандартуудыг мөрдөж байж болзошгүй дүгнэлт хийж болохоор байна.

Нэгтгэлд байгаль орчиныг хамгаалах, нөхөн сэргээлтийн мэдээг хамруулснаас зөвхөн 83 компанийн мэдээлэл олджээ. Нэгтгэлд уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгааг хамруулсан ч дөнгөж 128 компанийн мэдээллийг Ашигт малтмалын газраас гарган өгсөн байна.

Нэгтгэлд хамрагдсан томоохон ажлын нэг нь тусгай зөвшөөрлийн талаархи тоо баримт байсан. Нэгтгэлд хамрагдсан 200 компани 2011 оны эхэнд 382 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байсан бол оны эцэст 398 болж нэмэгдсэн бол харин хайгуулын 578 тусгай зөвшөөрөлтэй байсан бол 545 болж буурсан байна.

2011 оны эцсийн байдлаар нийт 1841 компани ашиглалтын 1200, хайгуулын 2576 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаар нь судалгаа хийхэд Төфис майнинг 63, Алтандорнод 35, үүнээс 29 нь ашиглалт, Монголросцветмет 36, үүнээс 33 нь ашиглалт, Пибодивинсвей ресорсиз 30, үүнээс 3 нь ашиглалт, Сентеррагоулд 27, үүнээс 7 нь ашиглалт, Гобикоул энд энержи 32, үүнээс 4 нь ашиглалт, МАК 31, үүнээс 22 нь ашиглалт, Гацуурт 21, үүнээс 18 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байна.

Нэгтгэлийн үеэр нутгийн удирдлагатай байгуулсан гэрээний судалгааг хийхийг оролдсон байна. Нийт 200 компаниас 21 нь гэрээний талаар мэдээллээ өгсөн бөгөөд олж мэдснээр 39 гэрээ байгуулагдсан байна гэдэг нь тодорхой болжээ. Харин аймаг орон нутгийн удирдлагаас гэрээний талаар ямар нэг мэдээлэл өгөөгүй ажээ.

Тайланд өмнө нь өгч байсан зөвлөмжүүдийг хүлээн авсан эсэхэд дүгнэлт хийж цаашид анхаарах асуудлуудаар зөвлөмж өгсөн байна. ОУИТБС- ын тайлагналд хойрго ханддаг байдлыг засах, уул уурхайн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой санхүүгийн хариуцлагыг сайжруулах, Ашигт малтмалын газрын мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах гээд хэд хэдэн зөвлөмж өгчээ.


ОУИТБС-ын ажлын алба

О- О- О

Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангуудын зарим үзүүлэлт

Тайлангийн жил	Тайланг нийтэлсэн огноо	Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоо	Тайлан гаргасан компанийн тоо	Материаллаг төлбөрийн босго (Аудитын нэгтгэлд орох босго төгрөгөөр)	Аудитын нэгтгэлд орсон компаниудын тоо	Засгийн газрын хүлээн авсан орлогын дүн /төгрөг/	Компанийн төлсөн дүн /төгрөг/	Шийдэгдээгүй зөрүү* (төгрөг)	Нэгтгэл хийсэн аудитын консорциум
2006	2007 оны 12 дугаар сар	134	64	200 сая <	25	467,2 тэрбум	492,3 тэрбум	4 тэрбум	Австралийн Крэйн Вайт энд АссошиэТС
2007	2009 оны 10 дугаар сар	184	102	200 сая <	38	748,8 тэрбум	745,0 тэрбум	775,1 сая	Малайз, Монголын Эрнст энд Янг
2008	2010 оны 5 дугаар сар	184	113	100 сая <	46	685,6 тэрбум	686,0 тэрбум	420 сая	Их Британийн Харт Нойрс Лтд болон Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК
2009	2011 оны 6 дугаар сар	363	129	50 сая <	101	737,5 тэрбум	737,5 тэрбум	58,1 сая	
2010	2012 оны 1 дүгээр сар	478	268	50 сая <	150	1 их наяд 275 тэрбум	1 их наяд 275 тэрбум	356,7 мянга	
2011	2012 оны 11 дүгээр сар	518	300	40 сая <	200	2 их наяд 150 тэрбум	2 их наяд 150 тэрбум	75,0 сая	

Жич: Шийдэгдээгүй зөрүү гэдэг нь аудитын нэгтгэлээр тайлбарлагдаагүй үлдсэн зөрүүний хэмжээ юм.



- Улсын төсвийн нийт татварын орлого
- Нэгтгэлийн тайлангаар нотлогдсон дүн

Дэлгэрэнгүйг: www.eitimongolia.mn -ээс